

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/533

Номгон

「Баянхонгор аймгийн стратеги төлөвлөгөө」  
боловсруулж, батлуулах ажлын хэсэг томилох  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх Газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалаар батлагдсан “Аргачлал, загвар батлах тухай” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн “Стратеги төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Г.Энхбаяр- Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга

Д.Энхжаргал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Норов - Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Баянмөнх –Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Сарангарав - Засаг даргын Тамгын газрын Хууль ,эрх зүйн хэлтсийн дарга

С.Байгалмаа - Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Наранбаяр- Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Хишигбаатар - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Нэмэхбаяр – Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

601210283

2.

Ц.Насанбаяр- Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Энхтүвшин- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимын дарга

Ж.Дуламсүрэн – Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ (зөвшилцсөнөөр )

В.Гүрсэд- Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга (зөвшилцсөнөөр )

“Цэнэг-дөрөв-цэнэг” ТТБ (зөвшилцсөнөөр )

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Мандал - Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


2. Нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг аймаг орон нутгийн урт, дунд богино хугацааны бодлогын баримт бичигт суурилан, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн, нөөцийн судалгаа, санхүүгийн эх үүсвэрийг тооцоолон, бодлогын баримт бичгийн зорилго зорилт, шалгуур үзүүлэлтээр үндэслэж, төрийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн саналыг авч хэлэлцүүлэг зохион байгуулж, бодлогын баримт бичгийг боловсруулж 2021 оны 9 дүгээр сард багтаан Засаг даргын зөвлөлд танилцуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

3.Дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг байгууллагын төсвөөс санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (С.Гэрэлмаа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Дэд бүтэц, хөдөө аж ахуй хариуцсан орлогч дарга (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/260 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН